

Э-Сонин



25 дахь дугаар

Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

ТОП-20 ИНДЕКСИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН САНХҮҮ ХЭВИЙН БАЙДАЛД ШИЛЖЛЭЭ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН МОБАЙЛ АППЛЕКЕЙШН "APPLE STORE"-Д ТАВИГДАЖ ХЭРЭГЛЭГЧДИЙН ХҮРТЭЭЛ БОЛЖ БАЙНА



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ТӨРӨӨС АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ЗӨВЛӨМЖ ГАРГАЛАА

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ӨНДӨРЛӨЛӨӨ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД



ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 11 дүгээр сарын арилжааны мэдээлэл болон 12 сард арилжаалагдах товч мэдээлэл .
- ТОП-20 индекст багтах компаниудын багцад өөрчлөлт орууллаа.
- МХБ нь 2014 оны 8 дугаар сараас эхлэн хэмнэлтийн горимд шилжсэн бол 2014 оны 12 дугаар сараас эхлэн хэвийн горимд шилжлээ.
- МХБ-ийн мобайл апплекейшн нь хэрэглэгчдийн хүртээл болоод удаагүй байна. 2014 оны 11-р сарын 31-ний байдлаар 500 гаруй хэрэглэгч тус апплекейшныг татаж аваад байна.
- Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл төрөөс авах зарим арга хэмжээний талаар зөвлөмж гаргалаа.
- МХБ-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны төлөөллийг хүлээн авч уулзлаа.
- СЗХ-ны зохицуулалтын байгууллагуудын чуулга уулзалт амжилттай болж өндөрлөлөө.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 11-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт 12 дугаар сарын 15-ны өдөр эхэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг утас: 11-313747 /116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний 389 дугаар тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан билээ. Энэхүү бондыг долоо хоног болгоны Мягмар гарагт арилжаалсан бөгөөд 11-р сард нийт 12.2 тэрбум төгрөгийн бондын арилжааг 4 өдрийн арилжаагаар арилжсан байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ / ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2014.11.04	ЗГЭБ-Б-12-274	12	45,020	15.795%	4,344,114,860.00
2014.11.11	ЗГЭБ-Б-52-275	52	2,304	16.25%	230,400,000.00
2014.11.18	ЗГЭБ-Б-12-276	12	55,337	15.99%	5,337,308,987.00
2014.11.25	ЗГЭБ-Б-28-277	28	24,961	16.3%	2,295,213,872.00
Нийт зарагдсан ЗГҮЦ			127.622		12,204,037,719.00

2014 ОНЫ 12 ДУГААР САРД АРИЛЖААЛАХ ЗГЖҮЦ-НЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр: Монгол Улсын Сангийн яам
2. Үнэт цаас гаргах зорилго: Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлага
3. Үнэт цаасны санал болгох хүрээ: Олон нийтэд санал болгох
4. Үнэт цаасны төрөл: Засгийн газрын энгийн үнэт цаас
5. Нэрлэсэн үнэ: 100,000 төгрөг
6. Нийт гаргах тоо: 872,378
7. Нийт үнийн дүн: 87,237,800,000 төгрөг
8. Үнэт цаасны үзүүлэлт:

ЗГҮЦ-ны төрөл	Тоо хэмжээ /Ширхэг/	Хугацаа /7 хоног/	Хүү төлөгдөх хэлбэр	Захиалга эхлэх өдөр	Арилжаа хаагдах өдөр
ЗГЭБ-Б-12	872,378.0	12	Хямдруулалттай	2014.11.26	2014.12.02
ЗГЭБ-Б-52	-	52	Сар бүр	2014.12.03	2014.12.09
ЗГЭБ-Б-12	-	12	Хямдруулалттай	2014.12.10	2014.12.16
ЗГЭБ-Б-28	-	28	Хямдруулалттай	2014.12.17	2014.12.23
ЗГЭБ-Б-12	-	12	Хямдруулалттай	2014.12.24	2014.12.30



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

ТОП-20 ИНДЕКСИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

ТОП-20 индексийн багцад багтаж буй “Улаанбаатар зочид буудал” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай СЗХ-ны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 376 тоот тогтоол гарсантай холбогдуулан тус үнэт цаасыг ТОП-20 индексийн багцаас хасч, “Дархан нэхий” ХК-ийн үнэт цаасыг орууллаа.

ТОП-20 индекс нь 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн шинэчилсэн багцаар тооцоологдож эхлэв.

ТОП-20 ИНДЕКС

Симбол	Компанийн нэр	Үйл ажиллагаа
1	APU АПУ ХК	Аж үйлдвэр
2	BAN Багануур ХК	Уул уурхай
3	BNG Баянгол зочид буудал ХК	Худалдаа үйлчилгээ
4	BDS Би ди сек ХК	Брокер, Дилерийн үйл ажиллагаа
5	GOV Говь ХК	Ноос ноолууран эдлэл
6	NEH Дархан нэхий ХК	Үйлдвэрлэл
7	JTB Женко тур бюро ХК	Худалдаа үйлчилгээ
8	BDL Могойн гол ХК	Уул уурхай
9	MSH Монгол шилтгээн ХК	Худалдаа үйлчилгээ
10	MDR Монголиа Девелопмент Ресорсес ХК	Барилга тээвэр
11	MCH Монголын цахилгаан холбоо ХК	Худалдаа үйлчилгээ
12	RMC Ремикон ХК	Аж үйлдвэр
13	SIL Силикат ХК	Үйлдвэрлэл
14	SUU Сүү ХК	Аж үйлдвэр
15	TTL Таван толгой ХК	Уул уурхай
16	TCK Талх чихэр ХК	Хүнс
17	UID Улсын их дэлгүүр ХК	Худалдаа үйлчилгээ
18	HGN Хөх ган ХК	Аж үйлдвэр
19	SHG Шарын гол ХК	Уул уурхай
20	SHV Шивээ овоо ХК	Уул уурхай



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН САНХҮҮ ХЭВИЙН БАЙДАЛД ШИЛЖЛЭЭ

Санхүүгийн зайлшгүй нөхцөл байдлаас шалтгаалан Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2014 оны 8 дугаар 04-ний өдрөөс эхлэн хэмнэлтийн горимд шилжсэн. Үүний хүрээнд байгууллагын дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, Тэргүүн дэд захирал, дэд захирал болон тэдгээрт үйлчлэх жолоочийн болон ажлын байрны тодорхойлолтод тэнцэхгүй шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн бусад орон тоог хэмнэх, томоохон худалдан авалтыг зогсоох, бүх төвшинд зардал хэмнэх зэрэг чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд нийт зардлын гүйцэтгэлийг 23 хувиар буурууллаа.

Ингэснээр Монголын хөрөнгийн бирж нь 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс санхүүгийн хэвийн горимд шилжих нөхцөл бүрдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар дотоодын болон гадаадын аливаа аж ахуйн нэгжид хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байна.

Хэмнэлтийн горим амжилттай хэрэгжих гол үндэс суурь нь тус биржийн нийт ажилтнууд өөрсдийн санаачилгаар цалингаа 30 хувиар бууруулах шийдвэрийг гаргасан явдал байлаа. Бараа үйлчилгээний үнийн өсөлттэй үед дээрх шийдвэрийг гаргаж байгууллагын санхүүг хэвийн байдалд хүргэхэд чухал нөлөө үзүүлсэн нийт хамт олондоо талархлаа илэрхийлье.

Хэдийгээр санхүүгийн хувьд хэмнэлтийн горимд байсан ч дээрх хугацаанд Монголд нэн ашигтай нөхцөлөөр Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаагаа дахин 3 жилээр сунгасан, Засгийн газрын үнэт цаасны арилжааг 3 жилийн дараагаар Хөрөнгийн биржид дахин сэргээсэн, хяналт, бүртгэл болон гишүүнчлэлийн цогц журмуудыг шинэчлэн Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулсан зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН МОБАЙЛ АППЛЕКЕЙШН “APPLE STORE”-Д ТАВИГДАЖ ХЭРЭГЛЭГЧДИЙН ХҮРТЭЭЛ БОЛЖ БАЙНА



Монголын хөрөнгийн биржийн Ухаалаг гар утсанд зориулан гаргасан апплекейшн нь 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Apple Store”-д “**MN Stocks**” нэрийн доор тавигдсан бөгөөд уг программыг ашигласнаар хэрэглэгч хувьцааны ханшийн мэдээллийг 5 минутын хоцрогдолтойгоор хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэх боломжтой болсон юм.

2014 оны 11 сарын 31 –ний байдлаар 500 гаруй хэрэглэгч тус апплекейшныг татаж аваад байна.

Цаашид хэрэглэгчдийн хүсэлт, санал дээр үндэслэн зохих өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийх болно.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ТӨРӨӨС АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ЗӨВЛӨМЖ ГАРГАЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлөөс салбарын хөгжлийн бодлогод эерэгээр нөлөөлөх шийдвэрийг УИХ, Засгийн газраас гаргах нь зүйтэй гэж үзэн тодорхой зөвлөмжийг 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гаргалаа.

Бодлогын зөвлөл нь үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой бодлогын дараах агуулгатай шийдвэрийг төрийн зохих институтээс гаргахыг зөвлөсөн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос уг зөвлөмжийг

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын дарга, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод, Монгол Улсын ерөнхий сайд, Монголбанк болон Сангийн яаманд тус тус хүргүүлээд байна.

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр Монголын хөрөнгийн биржийн явуулж буй бодлого, үйл ажиллагаа, Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны арилжаа, зах зээлд нэвтрүүлэх шинэ бүтээгдэхүүн мөн хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар харилцан санал солилцож, цаашид хамтран ажиллах тухай зөвлөлдөв.



Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай Монгол Улсын Сангийн Яам болон Монголбанк нь 2013 онд “Дотоодын валютаар зээл олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд энэхүү хөтөлбөрт Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх болон үүнийг хэрэгжүүлэхэд тус банкны оролцох эрх үүрэг тусгагдсан юм.

Дээрх зорилтыг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэх саналыг өмнө нь Монголын талаас Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Ерөнхийлөгч Сэр Сума Чикрабартид хүргүүлсний дагуу тус банкны Лондон хот дахь төв оффисын төлөөлөгчид Монголын хөрөнгийн биржид хүрэлцэн ирж уулзалт хийлээ. Хамтран ажиллах чиглэлийн талаарх яриа хэлэлцээг ойрын үед үргэлжлүүлэхээр хоёр тал санал нэгдэв.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ӨНДӨРЛӨЛӨӨ



Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, мэргэжлийн холбоод болон олон улсын байгууллага, төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан санхүүгийн салбарын нэгдсэн чуулга уулзалтыг 11 дүгээр сарын 20-ны өдөр Чингис зочид буудлын хурлын танхимд зохион байгуулж, арга хэмжээ амжилттай өндөрлөлөө.

Чуулга уулзалтын гол зорилго нь салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, хяналт зохицуулалт, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний боловсролыг дээшлүүлэх талаар болон салбарын хүрээнд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж, нэгдсэн зөвлөмж гаргах юм.

Тус чуулга уулзалтад “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар “Хөрөнгө оруулагчдын боловсролыг дээшлүүлэх нь” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцож, өөрийн санал дүгнэлтийг өглөө.



“ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ ФОРУМ АМЖИЛТТАЙ БОЛЛО



2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Үйлдвэр Хөдөө Аж ахуйн Яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржээс хамтран “Үйлдвэрийн салбарын хөгжилд хөрөнгийн зах зээлийн оролцоо” сэдэвт форумыг амжилттай зохион байгууллаа. Форумын гол зорилго нь санхүүжилт шаардлагатай байгаа

үйлвэрлэлийн төслүүд болон компаниудын төлөөллийг хөрөнгө оруулагчид, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч андеррайтеруудтай уулзуулах явдал байсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгчид өөрсдийн төслөө танилцуулан, СЗХ, МХБ, андеррайтерийн компаниудын төлөөлөл илтгэл тавьж хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон санхүүжилт татах боломжуудыг танилцууллаа.

Форумын төгсгөлд оролцогчид өөрсдийн туршлагаас хуваалцаж, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, өөр бусад сонирхсон асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД



Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 375, 376 дугаар тогтоолыг үндэслэн “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Бүртгэлийн журам”-ын дагуу “Улаанбаатар зочид буудал” ХК-ийн нийт 335,297 ширхэг, “Разноимпекс” ХК-ийн нийт 1,027,921 ширхэг, “Монел” ХК-ийн нийт 594,897 ширхэг, “Цасту” ХК-ийн 52,672 ширхэг, “Чимбай” ХК-ийн 492,911 ширхэг, “Туул баян” ХК-ийн нийт 150,230 ширхэг, “Модлог” ХК-ийн нийт 139,954 ширхэг хувьцааг тус тус үнэт цаасны бүртгэлээс хасах тухай шалгалтыг хийж, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Захирлын зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийг үндэслэн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн гүйцэтгэх захирлын 190,191 тоот тушаалаар нэр бүхий компанийн үнэт цаасыг бүртгэлээс хаслаа.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД

Дор нэр дурдсан компаниуд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороноос баталсан дүрэм, журамд заасан үүргээ удаа дараа үл биелүүлж байгаа тул “Үнэт цаасны тухай хууль”-ийн 85.1.3 дах заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №148 дугаар тогтоолоор 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн арилжааг түр зогсоосон байна. Үүнд:

- | | |
|---------------------------|-----------------------|
| 1. “Ундарга-Өмнөговь” ХК | 2. “Сав шим” ХК, |
| 3. “Хангал” ХК | 4. “Хүнс-Архангай” ХК |
| 5. “Дарзам” ХК | 6. “Ажлын хувцас” ХК |
| 7. “Чандмань –Уул” ХК | 8. “Төв-ус” ХК |
| 9. “Алмаас” ХК | 10. “Өв усжуулагч” ХК |
| 11. “Мөнхжим” ХК | 12. “Баянтоорой” ХК |
| 13. “Оргил Говь-Алтай” ХК | |

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСНИЙ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Эдийн засгийн үндэсний дээд сургуулийн Нягтлан бодох бүртгэл, Олон улсын эдийн засгийн 3 дугаар курс болон 4 дүгээр курсын оюутнууд хөрөнгийн зах зээлийн талаар танхимын сургалтаар олж авсан онол, арга зүйн мэдлэгээ батжуулах зорилгоор 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн үйл

ажиллагаатай танилцлаа. Оюутнуудыг Зах зээлийн хөгжлийн газрын Мэдээлэл олон нийттэй харилцах албаны Ахлах мэргэжилтэн Э.Намжилмаа хүлээн авч уулзан, хөрөнгийн биржийн явуулж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч, Арилжааны үйл явцын талаарх мэдээллийг мэргэжилтэн Ц.Бат-Эрдэнэ, данс хэрхэн нээлгэх талаар зааварчилгаа, зөвлөгөөг ажилтан О.Адьяа өгч, оюутнууд сонирхсон асуултандаа хариултыг авлаа. Оюутнууд Монголын хөрөнгийн биржээр зочилж, арилжааны үйл ажиллагаатай биечлэн танилцсанаар олж авсан мэдээллээр мэдлэгээ бататгахад дэмжлэг болсон ажил боллоо.

2014 оны 11 дүгээр сард Монголын хөрөнгийн биржийн Мэдээлэл олон нийттэй харилцах албаны мэргэжилтнүүд Улаанбаатар их сургуулийн 5 оюутан, Чингэлтэй дүүргийн 24 дүгээр дунд сургуулийн 12 ангийн 25 сурагч, Отгонтэнгэр дээд сургуулийн 20 оюутан, МУИСургуулийн 30 оюутан нийт 91 хүнд хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө тус тус өгч ажиллаа.



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ
ЭЭЛЖИТ СУРГАЛТ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ**

ТӨГСӨЛТИЙН БАЯР



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2014 оны 11 дүгээр сарын 24-ноос 28-ний хооронд зохион явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо. Энэ удаагийн сургалтанд амжилттай суралцсан 22 суралцагч сертификат гардан авлаа.

Сургалтанд цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2014 оны 12 дугаар сарын сүүлээр 15-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2014 оны 11 дүгээр сар


Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	2,637,729
Нийт үнийн дүн	14,759,853,534.50
Хэлцлийн тоо	758
Арилжигдсан үнэт цаасны тоо	61
Зах зээлийн үнэлгээ	1,466,111,909,231

ТОП-20 индекс

Хаалт	14,919.19
Өмнөх сарын хаалт	15,547.65
Өөрчлөлт /нэгж/	-628.46
Өөрчлөлт %/	-4.04
52 дөрлоо хоног дээд	17,160.49
доод	13,422.43

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	1,840,000	934,720,000	1	MBG	МОН-ИТ БУЛИГА	178,000	1,273,400,000
2	MBG	МОН-ИТ БУЛИГААР	178,000	1,273,400,000	2	UID	УЛСЫН ИХ ДЭЛГ	1,840,000	934,720,000
3	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	122,675	21,714,217	3	APU	АПУ	16,810	61,957,845
4	HBO	ХАЙ БИ ОЙЛ	95,379	40,910,568	4	HBO	ХАЙ БИ ОЙЛ	95,379	40,910,568
5	HBT	ХӨНГӨН БЕТОН	77,148	15,429,600	5	ME	МАТЕРИАЛИМПЕ	1,865	31,779,000

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	HBO	ХАЙ БИ ОЙЛ	391.00	550.00	159	40.66
2	EER	АРИГ ГАЛ	2,350.00	2,600.00	250	10.64
3	MBH	МОНГОЛ ШИЛТГЭЭН	649.96	690.00	40	6.16
4	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	90.90	95.00	4	4.51
5	EPS	МОНГОЛ АЛТ	3,500.00	3,600.00	100	2.86

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	DLG	МОНГОЛ МАХ ЭКСПО	6,500.00	5,500.00	-1,000	-15.38
2	SUL	ГАЗАР СУЛЖМЭЛ	55,200.00	47,000.00	-8,200	-14.86
3	UBH	УЛААНБААТАР ХИВС	14,500.00	12,400.00	-2,100	-14.48
4	HAM	МОНГОЛЫН ХӨГЖИЛ	4,300.00	3,700.00	-600	-13.95
5	UYN	МОНГОЛ САВХИ	1,100.00	951.00	-149	-13.55

Засгийн газрын үнэт цаас:

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ЗГЭБ-Б-12-274	45,020	4,344,114,860	15.795	100,000	96,493
2	ЗГЭБ-Б-52-275	2,304	230,400,000	16.25	100,000	100,000
3	ЗГЭБ-Б-12-276	55,337	5,337,308,987	15.99	100,000	96,451
4	ЗГЭБ-Б-28-277	24,961	2,295,213,872	16.3	100,000	91,952